

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн явцад үүссэн хүндрэл, эрх зүйн хийдлийг арилгах, улс төрийн намын үйл ажиллагааны бодит хэрэгцээ, Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд:

- Намын орон нутгийн байгууллагыг тус бүр нэг данстай ажиллах боломжийг бүрдүүлэх;
- Шийдвэр гаргах үйл ажиллагааны шуурхай байдлыг нэмэгдүүлэх;
- Далд санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, эрх зүйн бие даасан байдлыг хангах зэрэг өөрчлөлтийг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар улс төрийн намын дотоод үйл ажиллагааны үр ашиг, шуурхай байдал нэмэгдэж, орон нутгийн намын байгууллагын хэвийн үйл ажиллагаа сайжрах, улс төрийн санхүүжилтийн ил тод байдал бодитой нэмэгдэх, далд санхүүжилтийг арилгах, иргэн, хуулийн этгээдийн улс төрийн оролцооны эрхийн хэрэгжилт сайжрах ач холбогдолтой.

-oOo-